# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 20 (ТОЙМ)

Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 14 цаг 30 минутанд эхэлж, 18 цаг 05 минут хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 3 цаг 35 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд Чамейханы Багдалыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Х.Батболдод санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Говьсүмбэр, Хөвсгөл аймгуудад 2010 оны 10 дугаар сарын 17, 19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай | 1.2010 оны 10 дугаар сарын 17, 19-ний өдөр тус тус зохион байгуулсан Төрийн жинхэнэ албаны МШ-д тэнцсэн нийт 206 иргэн (Говьсүмбэр аймгийн 32, Хөвсгөл аймгийн 174)-ийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэснийг 1-2 дугаар хавсралтаар батлах,<br><br>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалд нь хамгийн өндөр оноо авсан иргэнийг нэр дэвшүүлж, томилуулахыг Говьсүмбэр, Хөвсгөл аймаг дахь ТАЗСЗ-ийн дарга нарт үүрэг болгох,<br><br>3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТАЗ-ийн гишүүн, ТА-ны Мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгасан тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | Төрийн албаны зөвлөлийн 15 жилийн ой угтаж зохион байгуулсан (15 багц ажлаар) ТАЗ-ийн Салбар зөвлөлүүдийн ажлыг | ➢ Яамны дэргэдэх салбар зөвлөлүүдээс:<br>Эхний ба Эрдэс, баялаг, эрчим хүчний яамны болон Эрүүл мэнд, Сангийн яамны |

| | | |
|---|---|---|
| | дүгнэсэн тухай | дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд эхний 3 байрт<br>➢ Агентлагийн дэргэдэх салбар зөвлөлүүдээс:<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх болон Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд эхний 3 байрт<br>➢ Аймаг, нийслэл дэх салбар зөвлөлүүдээс:<br>Төв аймаг дахь болон Орхон аймаг, Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд эхний 3 байрт тус тус шалгаруулан шагнахаар тогтов |
| 4 | Дархан-Уул аймгийн төрийн зарим байгууллагад төрийн жинхэнэ албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан дүнгийн мөрөөр хийсэн ажлын тайлан | |
| 5 | Төв аймагт төрийн жинхэнэ албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан дүнгийн тухай | |
| 6 | Зарим хүмүүсийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шалгаруулан шагнах тухай | Цэрэнбаатарын Алтанцацрал, Банзрагчийн Аръяа, Пагамын Базаррагчаа, Лхамсүрэнгийн Батбаяр, Миеэгомбын Батжаргал, Чимэдцэрэнгийн Бат-Өлзий, Нанцагийн Батсуурь, Батсүхийн Бямбажав, Лхасүрэнгийн Бямбасүрэн, Маналжавын Даваасүрэн, Рагчаагийн Лхагвадорж, Отгоны Сандагдорж, Гомбодоржийн Сувд, Дамдины Цогтбаатар, Түдэвийн Цэрэнпүрэв, Баасандоржийн Энхтөр, Сүхээгийн Эрдэнэтуяа нарын нийт 17 хүнийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шалгаруулан шагнаж, уг шагналд дагалдах мөнгийг МУ-ын ТАЗ-ийн 2009 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу тухайн байгууллагаас олгох тухай МУ-ын ТАЗ-ийн даргын шийдвэр гаргахаар тогтов. |